



# НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2001... оны ...06... дугаар  
сарын ...06... ны өдөр

№ 92.....

Улаанбаатар  
хот

## “Вижн” нүдний эмнэлгийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай Монгол улсын хуулийн 77 дугаар зүйлийн 2,4 дүгээр заалт, “Вижн” нүдний эмнэлэг хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2001 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 4 дүгээр тогтоолыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. “Вижн” нүдний эмнэлэг хамтарсан хөрөнгө оруулалттай компанийг 2001 оны 6 дугаар сарын 6-ны өдрөөс татан буулгасугай.

Хоёр. Монголын талын хөрөнгө оруулалтанд тооцож хувь нийлүүлсэн барилгыг / Хуучин нэрээр Элэг цэсний архаг өвчтэй хүүхдийн сувиллын барилга / Нийслэлийн өмчийн харилцааны газрын балансад шилжүүлсүгэй.

Гурав. Уг барилгын ашиглалт, хамгаалалттай холбоотой саналаа 2001 оны 6 дугаар сарын 25-ны дотор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Өмчийн харилцааны газар / П.Дэлгэрнаран / -т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-  
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-  
ДИЙН ДАРГА

Т.БИЛЭГТ

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-  
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-  
ДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.МАНАЛЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД

П.АЛТАНЦЭЦЭГ  
Т.БАДАМЖУНАЙ  
Д.БААСАНСҮРЭН  
Ц.БААТАРСАЙХАН  
С.НЯМЗАГД  
У.УЛАМБАЯР  
Г.ЭНХТҮВШИН